



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар A/31

Алтрага

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
эрх шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эзэмшил газар эзэмших эрхээ шилжүүлэн эзэмших 3 иргэнийг (24319м2) хавсралтаар баталсугай.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын захирамжийн хавсралтын холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

3.Захирамжаар газар өмчлөгч иргэдэд эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Д.Батсайхан), улсын бүртгэгч (Н.Азжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010071